



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/197

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дахь хэсгийн 2.1.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн санаачилгаар зохион байгуулж буй санхүүгийн боловсрол олгох “Level-Up” хөтөлбөрийн зардал, “YOUTH POWER-KHOVD” байгальд ээлтэй залуусын чуулга уулзалтын зардлын дэмжлэг, Итали улсын Турин хотод болсон Дэлхийн тусгай олимпын өвлийн наадмын цасны гуталтай гүйлтийн төрөлд “Алтан медаль” хүртсэн тамирчин Т.Солонго болон багш дасгалжуулагчдад хүндэтгэл үзүүлэх, Тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын ажилтан албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээний зардалд тус тус 7,637,800 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх зардалд зарцуулагдах 7,637,800 (долоон сая зургаан зуун гучин долоон мянга найман зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.АМАРСАНАА



8400001 0567
Zah A/197 Och

Аймгийн Засаг даргын 2025 оны
03 дугаар сарын 27-ны өдрийн
А/197 дугаар захирамжийн хавсралт



ТӨСВИЙН ЗАДАРГАА

Д/д	Арга хэмжээний нэр	Зориулалт	Нийт
1	Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн санаачилгаар зохион байгуулж буй санхүүгийн боловсрол олгох "Level-Up" хөтөлбөрийн зардалд	Хөлтэй стекир, баннер, үг хэллэг товхимол, цэвэр ус, хоолны зардал	1,107,800
2	"YOUTH POWER-KHOVD" байгальд ээлтэй залуусын чуулга уулзалтын зардлын дэмжлэг үзүүлэх зардалд	Үйл ажиллагааны зардлын дэмжлэг	2,500,000
3	Итали улсын Турин хотод болсон Дэлхийн тусгай олимпын өвлийн наадамьн цасны гуталтай гүйлтийн төрөлд "Алтан медаль" хүртсэн тамирчин Т.Солонго болон багш дасгалжуулагчдад хүндэтгэл үзүүлэх зардалд	Гарын бэлэг, дурсгалын зүйл, нэг удаагийн урамшуулал	2,986,000
4	Тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын ажилтан албан хаагдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий "Хамгийн чухал нь" зорилтот арга хэмжээний зардалд	Хоол, буудлын зардал	1,044,000
Дүн			7,637,800

-оОо-